

БАТЛАВ:

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА  Х.БАТТУЛГА



“АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН БАРИЛГЫГ
ЗАСВАРЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2020.03.03

Баян-Уул сум


Үндэслэл	Тус сумын ахуйн үйлчилгээний төв нь 2010 онд ОНТХөрөнгө оруулалтаар модон байшин барих уламжлалт аргаар баригдсан бөгөөд энэ хугацаанд засварын ажил хийгдэж байгаагүй, өрөө тус тус бүр уламжлалт зуухан галлагаатай, ханаар дулаан алдалттай, хаалга, цонхнууд муудсан зэргээс түрээслэгчид хэвийн үйл ажиллагаа явуулах боломж, иргэд тохь тухтай орчинд үйлчилгээ авах боломжгүй зэрэгт дүгнэлт хийж сумын “ОНХС”-ийн 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар хийгдэх шаардлагатай болсон.
Барилга, байгууламжийн байршил, чиглэл	Дорнод аймгийн Баян-Уул сум 4-р багийн нутаг дэвсгэрт “Соёлын төв”-ийн хойд талд
Захиалагч байгууллага:	Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар
Хөрөнгийн эх үүсвэр:	Сумын “ОНХС”-ийн хөрөнгө оруулалт
Зориулалт, хүчин чадал:	Үсчин, гутал засвар, жижиг хэвлэлийн үйлчилгээ, цахилгаан хэрэгслийн засвар зэргийг ажиллуулах 6 өрөө бүхий /17*8м/ нэг давхар модон хийцийн барилга

Архитектур
төлөвлөлтөд тавигдах
шаардлага

Барилгын үндсэн хийцийн засвар:
-Барилгын гадна 28x16 метр хэмжээтэй төмөр хашааг зураг төсөвт батлагдсан стандартын дагуу хийж гүйцэтгэн бетон зуурмагаар бэхжүүлэн суурьлуулж будах. Явган хүний жижиг хаалга болон машин орох том хаалгыг тусад нь шийдэх
-Гадна фасадыг дундаа хөөсөн дулаалгатай тод өнгийн металл сайдингаар брус модонд тогтоох ба дотор талд нь ус чийгнээс хамгаалсан зориулалтын материалыг хийж эрдэс хөвөнгөөр дулаална.
-Сумын төвийн нэгдсэн дулаан хангамжийн системээс 32Ф-ийн хар трубагаар гадна монтажийг угсарч, зориулалтын хөөсөнцрөөр трубаг дулаалж булна. /гадна монтажийн эхлэл, төгсгөл дээр бөмбөлгөн хаалт хий авагч болон манометрийг хийх/
-Дотор монтажийг 25Ф-ийн хар трубагаар угсарч, нэг бүр нь 100x60см хэмжээтэй 10 ширхэг иж бүрэн ширмэн радиаторыг цонх бүрийн доод хэсэгт суурьлуулах, будах
-Гадна дотор хаалгыг барилгын одоо ашиглагдаж байгаа хаалганы гадна хэмжээг авч төмөр хаалгаар сольж суурьлуулах.
-Дотох ханын гипсэн хавтанг өнгийг сэргээн эмульсдэх, муудсан хэсгийг солих
-Шалны муудсан хэсгийг засварлан нөхөх /хулдаас/, коридорт паркетан шал хийх /захиалагчтай зөвшилцөх/
-Дээврийн гадна хүрээг шинээр хайрцаглан хийж будах
-Дээврийн төмрийн өнгийг сэргээн бүхэлд нь будах
-Зураг төсөвт болон ажлын даалгаварт тусгагдснаас бусад жижиг гэмтэл, эвдрэлийг засварлах, солих
-Коридорт гэрэл суулгах
-Пийшин буулгаж хана өрөх
-Хажуу самсааг төмөрлөх
-Гэрэлтдэг хаяг хийх /АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ/ 260Х40 СМ

БОЛОВСРУУЛСАН:

БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



/ Ш.ТӨМӨР-ИВЭЭЛТ/